



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй 9,900,000.00 (есөн сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Заяабал, Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Баярт-Од нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.3. Авсан арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


 Б. ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 А. АРИУНБОЛД

0000289

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн  
143... дугаар тогтоолын хавсралт



Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашин

| Д/д | Автомашины марк, улсын<br>дугаар, арал    | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Балансын үнэ<br>(төгрөг)                       | Сэлбэгээр<br>худалдсанаас олох<br>орлогын доод хэмжээ<br>(төгрөг) |
|-----|-------------------------------------------|-----------------------------------------|------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
| 1   | Блуетбирд, 30-28 ДАХ, арал<br>№FG10131091 | 2004/<br>2013                           | 9,900,000.00                                   | 500,000.00                                                        |
|     | Нийт дүн                                  |                                         | 9,900,000.00<br>(есөн сая есөн зуун<br>мянган) | 500,000.00<br>(таван зуун мянган)                                 |